



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/85

Батноров сум

Малжуулах арга хэмжээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/196 дугаар тушаалын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны “Малчдыг малжуулах” арга хэмжээнд Эрдэнэчандмань 1 дүгээр багийн малчин Пүрэвдоржийн Хэрлэнбаяр, Эрдэнэбаатарын Элбэг, Нэргүйн Эрдэнэболд, Баян 3 дугаар багийн малчин Ойдовын Цогбаяр, Баянбулаг 4 дүгээр багийн малчин Намнангийн Баярхүү, Идэрмэг 5 дугаар багийн малчин Өлзийбаярын Батболд, Мөнхбаярын Лхагвасүрэн, Өлзийбаярын Даваажаргал нарыг хамруулсугай.

2. “Малчдыг малжуулах” арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Баяртуяа)-д даалгасугай.



Б.ЖАВХЛАНБАЯР